

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

ТЕРРОРИЗМТОЙ ТЭМЦЭХ ТУХАЙ ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. 2004 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр баталсан Терроризмтой тэмцэх тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

ЭРҮҮГИЙН ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. 2015 оны 12 дугаар сарын 03-ны өдөр баталсан Эрүүгийн хуульд доор дурдсан агуулгатай хэсэг, заалт нэмсүгэй:

1/29.8 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн тайлбар:

“Тайлбар: - Энэ зүйлд заасан “объект барьцаалсан” гэж тээврийн хэрэгсэл, барилга байгууламж, хүн амын амьдралыг хангах болон олон улсын хамгаалалтад байдаг объект барьцаалсан үйлдлийг ойлгоно.”

2 дугаар зүйл. 2015 оны 12 дугаар сарын 03-ны өдөр баталсан Эрүүгийн хуулийн зүйл, хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/20.2 дугаар зүйл:

“20.2 дугаар зүйл. Террорист үйл ажиллагаанд уриалах, түүнийг нийтийн өмнө зөвтгөх, хатгах

1. Терроризмын суртал ухуулга явуулсан, түүнийг дэлгэрүүлсэн, террористүйл ажиллагаа явуулахыг олон нийтэд уриалсан, зөвтгөсөн, эсхүл бусад этгээдийг хатгасан бол нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан гэмт хэргийг төрийн албан хаагч үйлдсэн бол таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.”

2/29.8 дугаар зүйлийн гарчиг, мөн зүйлийн 1 дэх хэсэг:

“29.8 дугаар зүйл. Террорист үйлдэл хийх

1. Төр, олон улсын байгууллагаас тодорхой шийдвэр гаргуулах, гаргасан шийдвэрийг өөрчлүүлэх, шийдвэр гаргахаас татгалзуулах зорилгоор галт зэвсэг, тэсэрч дэлбэрэх, цөмийн бодис, цацраг идэвхт хаягдал, хими, биологийн хортой, аюултай бодис, цахим сүлжээ, техник хэрэгсэл, тусгайлан бэлтгэсэн зэвсгийн чанартай зүйлийг ашиглаж, ашиглахаар заналхийлж хүн амыг айдаст автуулсан; галдан шатаасан, хүн хулгайлсан, хүн, объект барьцаалсан, хүнийг алсан, эрүүл мэндэд хохирол учруулсан; зэвсэгт мөргөлдөөний нөхцөлд сөргөлдөгч аль нэг талд идэвхтэй оролцоогүй хүний амь бие, бие махбодид халдсан хүнийг арван хоёр жилээс хорин жил хүртэл хугацаагаар, эсхүл бүх насаар хорих ял шийтгэнэ.”

3/29.10 дугаар зүйлийн 2, 3, 4 дэх хэсэг, мөн зүйлийн 4 дэх хэсгийн тайлбар:

“2. Энэ гэмт хэргийг хориг арга хэмжээг зөрчиж үйлдсэн бол найман жилээс арван таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.”

3. Энэ гэмт хэргийг хориг арга хэмжээг зөрчиж хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол хуулийн этгээдийг тодорхой үйл ажиллагаа явуулах эрхийг хасаж хуулийн этгээдийг албадан татан буулгана.

4. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол хуулийн этгээдийг тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрх хасаж нэг зуун хорин мянган нэгжээс дөрвөн зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

Тайлбар: - Энэ зүйлд заасан “хориг арга хэмжээ” гэж Нэгдсэн Үндэстний Байгууллагын Аюулгүйн зөвлөлийн тогтоолоор батлагдсан терроризмтой тэмцэх болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхтэй тэмцэхтэй холбоотой санхүүгийн хориг арга хэмжээ, түүнд үндэслэн терроризмтой тэмцэх чиг үүрэг бүхий байгууллагаас баталсан жагсаалтад орсон хүн, хуулийн этгээдийн эсрэг санхүүгийн хориг арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг ойлгоно.

- Энэ зүйлд заасан гэмт хэргийн талаар төрийн зохих байгууллагад сайн дураараа даруй мэдэгдсэн, учирч болзошгүй хохирлоос урьдчилан сэргийлэхэд туслалцаа үзүүлсэн иргэний үйлдэл нь өөр гэмт хэргийн шинжгүй бол ялаас чөлөөлнө. Энэ зүйлийн 1, 3 дахь хэсэгт энэ тайлбар хамаарахгүй.”

4/29.10 дугаар зүйлийн гарчиг, мөн зүйлийн 1 дэх хэсэг:

“29.10 дугаар зүйл. Терроризмыг санхүүжүүлэх

1. Террорист этгээд, террорист үйлдэл, террорист үйл ажиллагаанд зарцуулагдахыг урьдчилан мэдсээр байж шууд, шууд бусаар эд хөрөнгө хуримтлуулсан, өөрчилсөн, шилжүүлсэн, зарцуулсан бол таван жилээс арван хоёр жил хүртэлхугацаагаар хорих ял шийтгэнэ.”

5/29.11 дүгээр зүйл:

“29.11 дүгээр зүйл. Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх

1. Монгол Улсын олон улсын гэрээгээр хориглосон хими, биологийн, эсхүл үй олноор хөнөөх бүх төрлийн зэвсэг, тэдгээрийн түүхий эд, эд зүйл, тоног төхөөрөмж, технологийг боловсруулах, үйлдвэрлэх, хуримтлуулах, олж авах, худалдах үйл ажиллагаанд зарцуулагдахыг мэдсээр байж шууд, эсхүл шууд бусаар эд хөрөнгө хуримтлуулсан, өөрчилсөн, шилжүүлсэн, зарцуулсан бол таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

2. Энэ гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол хуулийн этгээдийг тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрх хасаж нэг зуун хорин мянган нэгжээс дөрвөн зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгож, хуулийн этгээдийг албадан татан буулгана.”

3 дугаар зүйл. 2015 оны 12 дугаар сарын 03-ны өдөр баталсан Эрүүгийн хуулийн 20.1 дүгээр зүйлийн гарчийн “Террор үйлдэх” гэснийг “Террорист үйлдлийн” гэж, 29.9 дүгээр зүйлийн гарчийн “Террор үйлдэхэд” гэснийг “Террорист

ТӨСӨЛ

үйлдэлд” гэж, мөн зүйлийн 1 дэх хэсгийн “Terrror” гэснийг “Террорист” гэж, мөн зүйлийн 2 дахь хэсгийн тайлбарын “Terrror ажиллагааг” гэснийг “Террорист үйлдлийг” гэж тус тус нэмсүгэй.

4 дүгээр зүйл.Энэ хуулийг Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны ... дугаар
сарын ... –ны өдөр

Улаанбаатар
хот

ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛЬТУХАЙ

1 дүгээр зүйл. Зөрчлийн тухай хуулийн 5.10 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“5.10 дугаар зүйл. Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хууль зөрчих

1. Терроризмтой холбоотой мэдээ, мэдээллийг төрийн байгууллагад даруй өгөх, террорист үйл ажиллагаа, үйлдэлд өдөөн хатгасан аливаа явуулга, суртал ухуулга, үзэл санаанд автахгүй байх, терроризмыг сурталчлах, олон нийтэд уриалах, нийтийн өмнө зөвтгөх аливаа үйл ажиллагаа явуулахгүй байх, терроризмоос сэргийлэх, террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагааг явуулах, хохирол, хор уршигийг арилгах, сэргээн босгох ажиллагаанд дэмжлэг, туслалцаа үзүүлэх үүргээ биелүүлээгүй бол хүнийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

2. Хориг арга хэмжээний жагсаалтад орсон хүн, хуулийн этгээдийг шууд болон шууд бусаар санхүүжүүлэх, түүнд эдийн засгийн эх үүсвэр олгох, санхүүгийн болон бусад бүх төрлийн үйлчилгээ, туслалцаа, дэмжлэг үзүүлсэн бол зөрчилийн үнийн дүнтэй тэнцэх хэмжээний хөрөнгө, орлогыг хурааж хүнийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

3. Зөвлөлийн терроризмоос сэрэмжлүүлэх талаар өгсөн үүрэг, эсхүл Шуурхай штабын хүсэлт, шаардлагыг хүн, хуулийн этгээд нэн даруй биелүүлэх, эсхүл түүнд бүх талын дэмжлэг, туслалцаа үзүүлэх үүргээ биелүүлээгүй бол хүнийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

4. Хориг арга хэмжээний жагсаалтад орсон хүн, хуулийн этгээд, тэдгээрийг санхүүжүүлдэг этгээдийн шууд эсхүл шууд бус өмчлөл, эсхүл хяналтад байгаа хөрөнгийг даруй царцааж тагнуулын байгууллагад 24 цагийн дотор мэдээлэх үүргээ биелүүлээгүй бол зөрчилийн үнийн дүнтэй тэнцэх хэмжээний хөрөнгө, орлогыг хурааж хүнийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

**ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ
ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.2017 оны 5 дугаар сарын 18-ны өдөр баталсан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 6.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.1 дэх заалтын “29.10 /Террор үйлдэхийг санхүүжүүлэх/ дугаар” гэснийг “29.10 /Террор үйлдэхийг санхүүжүүлэх/, 29.11 /Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх/ дүгээр” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрднө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны ... дугаар
сарын ... –ны өдөр

Улаанбаатар
хот

ЗӨРЧИЛ ШАЛГАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛЬ

1 дүгээр зүйл. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 6.18 дугаар зүйлийн "хуулийн" гэсний араас "5.10 дугаар зүйлийн 2, 3, 4 дэх хэсэг," гэж, 6.19 дүгээр зүйлийн "хуулийн" гэсний араас "5.10 дугаар зүйлийн 2, 3, 4 дэх хэсэг," гэж тус тус нэмсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны ... дугаар
сарын ... –ны өдөр

Улаанбаатар
хот

МӨНГӨ УГААХ БОЛОН ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ ТЭМЦЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд доор дурдсан агуулгатай хэсэг нэмсүгэй:

1/18 дугаар зүйлийн 18.6 дахь хэсэг:

“18.6. Санхүүгийн мэдээллийн алба нь үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр эрх бүхий байгууллагатай хамтран ажиллаж, мэдээлэл солилцож, гэмт хэргийг мөрдөн шалгах, хянан шийдвэрлэх ажиллагаанд дэмжлэг, туслалцаа үзүүлнэ.”

2 дугаар зүйл. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн дараах хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/6¹ дугаар зүйлийн 6^{1.1}. дэх хэсэг:

“6^{1.1}. Энэ хуулийн 4.1-д заасан этгээд нь Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хуулийн 3.1.17-д заасан жагсаалтад орсон хүн, хуулийн этгээдэд, аливаа бүлэг, нэгдэлд аливаа үйлчилгээ үзүүлэхийг хориглоно.”

2/5 дугаар зүйлийн 5.5 дахь хэсэг:

“5.5. Энэ хуулийн 4.1-д заасан этгээд нь харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагааг энэ хуулийн 5.14-т заасан журмын дагуу эрсдэлийн үнэлгээнд үндэслэн энэ хуулийн 5.2.1, 5.2.2-т заасан хүрээнд хялбаршуулсан байдлаар хийж болно.”

2/3 дугаар зүйлийн 3.1.2 дахь заалт:

“3.1.2. “терроризмыг санхүүжүүлэх” гэж террорист этгээд, террорист үйлдэл, эсхүл террорист үйл ажиллагаанд зарцуулагдахыг мэдсээр байж шууд, эсхүл шууд бусаар эд хөрөнгө хуримтлуулсан, өөрчилсөн, шилжүүлсэн, зарцуулсныг,”

3/3 дугаар зүйлийн 3.1.11 дэх заалт:

“3.1.18.“үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх” гэж Монгол Улсын олон улсын гэрээ, хууль тогтоомжоор хориглосон цөмийн, химийн, биологийн, эсхүл үй олноор хөнөөх бүх төрлийн зэвсэг, тэдгээрийн түүхий эд, эд зүйл, тоног төхөөрөмж, технологи /хууль бусаар олж авсан хоёрдмол зориулалттай бараа, бүтээгдэхүүн/-ийг боловсруулах, үйлдвэрлэх, эзэмших, хадгалах, олж авах, тээвэрлэх, экспортлох, шилжүүлэх, хуримтлуулах, худалдах, худалдан авах, ашиглахад бүрэн, эсхүл хэсэгчилсэн санхүүгийн дэмжлэг, үйлчилгээ үзүүлэхийг;”

4/18 дугаар зүйлийн 18.1.3 дахь заалт:

“18.1.3. мэдээлэх үүрэгтэй этгээдийн сэжигтэй гүйлгээг илрүүлэх, мэдээлэх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилгоор сэжигтэй гүйлгээнд хийсэн дүн шинжилгээний талаарх ерөнхий мэдээлэл, сэжигтэй гүйлгээний нийтлэг хэв шинж, арга хэлбэрийн талаар тогтмол мэдээлэх.”

3 дугаар зүйл. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 6¹ дүгээр зүйлийн 6^{1.2}. дахь хэсгийн “тухай” гэсний дараа “тагнуулын байгууллага,” гэж, мөн хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсгийн “4.1.7” гэсний дараа “4.1.8” гэж, “4.1.9-д заасан этгээд энэ хуулиар хүлээсэн үргээ хэрхэн биелүүлж байгаад хяналт тавих, хэрэгжилтийг хангуулах ажлыг” гэсний дараа “Хуульчдийн холбоо, мэргэшсэн нягтлан бодогчийн эрх олгох Институт” гэж нэмсүгэй.

4 дүгээр зүйл. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсгийн “энэ хуулийн” гэсний дараах “4.1.8,” гэснийг хассугай.

5 дугаар зүйл. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 5.5.1, 5.5.2 заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

**САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ
ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд доор дурдсан агуулгатай заалт нэмсүгэй:

1/3 дугаар зүйлийн 3.1.8¹, 3.1.8² дахь заалт:

“3.1.8¹. Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаа;”

“3.1.8². Үл хөдлөх эд хөрөнгө, зуучлалын байгууллагын үйл ажиллагаа;”

2 дүгээр зүйл. Энэ хуулийг Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

**НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд доор дурдсан агуулгатай заалт нэмсүгэй:

1/26 дугаар зүйлийн 26.1.7 дахь заалт:

"26.1.7. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 4.1.9-т заасан этгээд үүргээ хэрхэн биелүүлж байгаад, хяналт тавих, хэрэгжилтийг хангуулах."

2 дүгээр зүйл. Энэ хуулийг Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны ... дугаар
сарын ... –ны өдөр

Улаанбаатар
хот

ХУУЛЬЧИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ
ТУХАЙ

1 дүгээр зүйл. Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуульд доор дурдсан агуулгатай хэсэг нэмсүгэй:

1/63 дугаар зүйлийн 11 дэх хэсэг:

“63.11. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 4.1.9-т заасан этгээд үүргээ хэрхэн биелүүлж байгаад, хяналт тавих, хэрэгжилтийг хангуулах.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны ... дугаар
сарын ... –ны өдөр

Улаанбаатар
хот

ТАГНУУЛЫН БАЙГУУЛЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Тагнуулын байгууллагын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.10 дахь хэсэгт доор дурдсан агуулгатай заалт нэмсүгэй:

1/10 дугаар зүйлийн 10.10.4 дэх заалт:

“10.10.4. эдийн засгийн тагнуулын ажиллагаа явуулах;”

2 дугаар зүйл. 10 дугаар зүйлийн 10.4 дэх хэсгийн “сөрөх тагнуул,” гэсний дараа “эдийн засгийн тагнуул,” гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл. 10 дугаар зүйлийн 10.10 дахь хэсгийн 10.10.4, 10.10.5, 10.10.6, 10.10.7 дахь заалтын дугаарыг “10.10.5, 10.10.6, 10.10.7, 10.10.8” гэж тус тус өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл. Энэ хуулийг Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ